



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/126

Мандалговь

Дундговь аймгийн Музейд дохиолол
хамгаалалтын тоног төхөөрөмж хүлээлцэх
ажлын комисс томилох тухай

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 11.4, 16.3 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Дундговь аймгийн Музейд дохиолол хамгаалалтын тоног төхөөрөмж нийлүүлэх” ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Мөнгөн (Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Мэдээллийн технологийн ажилтан)

Нарийн бичгийн дарга: Э.Эрдэнэсүх (Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Т.Бямбажав (Музейн дарга)
Ш.Цэрэндаш (Музейн нярав)
Э.Сүхбат (“Тэлмэн нетворк” ХХК-ийн захирал)

Хоёр. Музейн дохиолол хамгаалалтын тоног төхөөрөмжийг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Н.Мөнгөн)-д даалгасугай.

ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060524